



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр  
сарын 2-ны өдөр

Дугаар 429


Улаанбаатар  
хот

Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх авто  
замын ажлын талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг  
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500.0 (таван зуун) сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн 135.5 (нэг зуун гучин таван сая таван зуун мянган) сая ам.долларын хөрөнгөөр санхүүжүүлэх “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам”, “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам”-ын барилгын ажлыг хятадын талын санал болгосон компаниудаас сонгон, гэрээ байгуулсны үндсэн дээр эхлүүлж, гүйцэтгэлд нь зохих журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд М.Зоригтод үүрэг болгосугай.

2. “Улаанбаатар хот-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудал чиглэлийн хурдны авто зам”, “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам”-ын барилгын ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанитай гэрээ байгуулж ажиллахыг Зам, тээврийн сайд М.Зоригтод, шаардагдах хөрөнгийг Засгийн газрын 2015 оны 309 дүгээр тогтоолын хавсралтад заасан хөрөнгөд багтаан санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Болор, Зам, тээврийн сайд М.Зоригт нарт тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

М.ЗОРИГТ